ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын 1 -р сургуулийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДГА-2023/130/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.dornogovi@audit.gov.mn

Дорноговь аймаг

Сайншанд сум

2023 он


Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас:70523020
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа
Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn
2023.02.24 № 1-6/202
танай ______ -ны № ______ -т

САЙНШАНД СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 1-Р СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Г.ГАНБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын 1-р сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын 1-р сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус; аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөг суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд

0190'''4'1

чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын 1-р сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг өмнөх онтой харьцуулахад мөнгөн хөрөнгийн дансанд их хэмжээний өөрчлөлт орсон байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 262.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Илрүүлэлтээр шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 4,042.4 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 2,847.4 сая төгрөгийн 57 гүйлгээ, 226.1 сая төгрөгийн 26 шийдвэрийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 359.0 сая төгрөгийн орлогын 12 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 276.6 сая төгрөгийн зарлагын 17 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 81.4 сая төгрөгийн 4 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 17 зорилтын 35 арга хэмжээний хэрэгжилт 82.5 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 92.7 хувийн биелэлттэй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **240,315,612.48** | **474,667,760.80** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 262,011,765.38 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 262,011,765.38 |
| **3121** | **Төгрөг** | - | 262,011,765.38 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 262,011,765.38 |
| **33** | **АВЛАГА** | 26,966,833.97 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 490,514.87 | - |
| **335** | **Бусад авлага** | 26,476,319.10 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 26,476,319.10 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 213,348,778.51 | 212,655,995.42 |
| **351** | **Түүхий эд материал** | 3,852,487.20 | 3,132,774.80 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 2,155,670.00 | 2,155,670.00 |
| 35130 | Эм боох материал | 1,696,817.20 | 977,104.80 |
| **354** | **Хангамжийн материал** | 202,461,291.31 | 185,953,220.62 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,986,500.00 | 4,798,250.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,728,100.00 | 16,883,172.76 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 270,000.00 | - |
| 35450 | Барилгын засварын материал | 31,900.00 | 179,520.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,452,606.00 | 3,735,551.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 194,992,185.31 | 160,356,726.86 |
| 35600 | Мал амьтад | 7,035,000.00 | 23,570,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **7,022,721,045.57** | **7,379,498,941.06** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 7,022,721,045.57 | 7,379,498,941.06 |
| **392** | **Биет хөрөнгө** | 6,566,147,670.49 | 6,923,439,815.90 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 6,729,852,619.49 | 7,215,329,199.49 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (551,776,222.88) | (773,869,647.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 582,759,054.62 | 615,863,393.07 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (404,718,385.53) | (368,006,246.78) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 342,687,636.07 | 324,197,435.40 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (169,103,817.74) | (182,317,213.00) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 294,002,454.11 | 293,224,646.61 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (277,164,448.65) | (219,954,934.89) |
| 39217 | Ном | 19,608,781.00 | 18,973,183.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 456,573,375.08 | 456,059,125.16 |
| 39301 | Програм хангамж | 5,061,320.00 | 2,057,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (3,607,944.92) | (1,117,874.84) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 455,120,000.00 | 455,120,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **7,263,036,658.05** | **7,854,166,701.86** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **901,091.39** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 901,091.39 |
| **413** | **Өглөг** | - | 901,091.39 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 901,091.39 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **7,263,036,658.05** | **7,853,265,610.47** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 7,263,036,658.05 | 7,853,265,610.47 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,560,383,319.33 | 1,560,383,319.33 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,842,991,350.68 | 3,433,220,303.10 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,842,991,350.68 | 2,954,107,931.78 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 479,112,371.32 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,859,661,988.04 | 2,859,661,988.04 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **7,263,036,658.05** | **7,854,166,701.86** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,929,545,121.05** | **3,589,446,374.27** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **834,083,036.43** | **539,538,837.26** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 834,083,036.43 | 539,538,837.26 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө | 801,385,901.29 | 499,385,242.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Бараа материал | 32,697,135.14 | 40,153,595.26 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,095,462,084.62** | **3,049,907,537.01** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,717,602,400.00 | 2,598,716,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 2,598,716,000.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,717,602,400.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 34,936,529.10 | 5,278,200.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,561,769.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 22,374,760.10 | 5,278,200.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 342,923,155.52 | 445,913,337.01 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 342,923,155.52 | 445,913,337.01 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,550,311,464.88** | **3,090,499,366.05** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,550,311,464.88** | **3,090,499,366.05** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,547,352,437.88 | 2,865,739,266.05 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,375,406,934.73 | 1,737,813,362.26 |
| 210101 | Үндсэн цалин | 894,544,504.23 | 1,259,371,118.26 |
| 210102 | Нэмэгдэл | 407,776,930.50 | 445,085,950.00 |
| 210104 | Урамшуулал | 73,085,500.00 | 33,356,294.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 175,855,594.00 | 220,923,467.32 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 130,011,098.19 | 153,006,917.36 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,546,233.37 | 17,847,059.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,083,666.44 | 13,958,427.45 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,292,297.80 | 3,308,670.36 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,922,298.20 | 32,802,392.99 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 323,123,230.52 | 366,824,306.01 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,386,536.52 | 11,795,602.01 |
| 210302 | Түлш, халаалт | 298,435,306.00 | 310,387,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 16,301,388.00 | 44,641,704.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 56,942,628.46 | 76,316,018.55 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,940,240.00 | 4,916,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,045,000.00 | 270,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 601,970.00 | 75,735.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,328,120.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 25,118,726.56 | 12,752,529.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 25,908,571.90 | 58,300,954.55 |
| **2105** | **Нормативт зардал** | 93,827,669.20 | 55,643,162.80 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,083,190.20 | 1,461,525.80 |
| 210502 | Хоол, хүнс | 90,744,479.00 | 54,181,637.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,121,730.00 | 2,610,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,121,730.00 | 2,610,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 17,232,860.00 | 15,682,910.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16,210,860.00 | 152,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,022,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 15,530,910.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 498,841,790.97 | 389,925,739.11 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 680,000.00 | 41,572,696.40 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,828,000.00 | 19,935,260.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 496,333,790.97 | 328,417,782.71 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,959,027.00 | 224,760,100.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,740,000.00 | 224,760,100.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 210,560,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,740,000.00 | 14,200,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,219,027.00 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,219,027.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **379,233,656.17** | **498,947,008.22** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 2,090,600.00 | 19,834,636.90 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 11,934,636.90 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал -Бараа материал | 2,090,600.00 | 7,900,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (2,090,600.00) | (19,834,636.90) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 377,143,056.17 | 479,112,371.32 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,095,462,084.62** | **3,105,718,754.11** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **52,194,948.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 52,194,948.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | - | 17,779,300.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 17,779,300.00 |
| 1200047 | Шилужүүлэн авсан хөрөнгө | | 34,415,648.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,095,462,084.62** | **3,053,523,806.11** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,717,602,400.00 | 2,598,716,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 2,598,716,000.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,717,602,400.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 34,936,529.10 | 8,894,469.10 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,561,769.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 22,374,760.10 | 8,894,469.10 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 342,923,155.52 | 445,913,337.01 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 342,923,155.52 | 445,913,337.01 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,053,121,934.62** | **2,742,662,848.73** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,053,121,934.62** | **2,742,662,848.73** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,984,253,338.52** | **2,517,405,348.73** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,353,047,000.00 | 1,735,745,742.19 |
| 210101 | Үндсэн цалин | 890,981,015.50 | 1,259,690,293.19 |
| 210102 | Нэмэгдэл | 388,980,484.50 | 443,133,163.00 |
| 210104 | Урамшуулал | 73,085,500.00 | 32,922,286.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 175,855,594.00 | 221,599,481.13 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 130,011,098.19 | 153,682,931.17 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,546,233.37 | 17,847,059.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,083,666.44 | 13,958,427.45 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,292,297.80 | 3,308,670.36 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,922,298.20 | 32,802,392.99 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 323,123,230.52 | 366,824,306.01 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,386,536.52 | 11,795,602.01 |
| 210302 | Түлш, халаалт | 298,435,306.00 | 310,387,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 16,301,388.00 | 44,641,704.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 20,528,332.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 3,772,100.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,000,000.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 601,970.00 | - |
| 210404 | Ном, хэвлэл | 1,209,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,047,100.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,898,162.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 34,916,187.00 | 54,788,140.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 835,997.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 31,441,990.00 | 54,788,140.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,638,200.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 34,815,825.00 | 7,490,895.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 14,129,400.00 | - |
| 210602 | Тавилга | 691,500.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 19,994,925.00 | 7,490,895.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 18,796,800.00 | 35,032,510.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 17,774,800.00 | 12,303,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,022,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 22,729,010.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 23,170,370.00 | 95,924,274.40 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 680,000.00 | 61,747,874.40 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 22,490,370.00 | 34,176,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **68,868,596.10** | **225,257,500.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 62,675,700.00 | 225,257,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 60,680,700.00 | 211,057,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,995,000.00 | 14,200,000.00 |
| 213305 | нэмэлт санхүүжилт төвлөрүүлэн шилжүүлэг | 4,973,869.10 | |

| | | | |
|---|---|---|---|
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,219,027.00 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,219,027.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **42,340,150.00** | **363,055,905.38** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **42,340,150.00** | **101,044,140.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **42,340,150.00** | **101,044,140.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 42,340,150.00 | 101,044,140.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 34,378,000.00 | 101,044,140.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 7,962,150.00 | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(42,340,150.00)** | **(101,044,140.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | 262,011,765.38 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 262,011,765.38 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,560,383,319.33 | 2,859,661,988.04 | 2,842,991,350.68 | 7,263,036,658.05 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,560,383,319.33** | **2,859,661,988.04** | **2,942,991,350.68** | 7,363,036,658.05 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,560,383,319.33** | **2,859,661,988.04** | **2,842,991,350.68** | 7,263,036,658.05 |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,560,383,319.33** | **2,859,661,988.04** | **2,842,991,350.68** | 7,263,036,658.05 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 111,116,581.10 | 111,116,581.10 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,560,383,319.33** | **2,859,661,988.04** | **2,842,991,350.68** | 7,263,036,658.05 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 479,112,371.32 | 479,112,371.32 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,560,383,319.33** | **2,859,661,988.04** | **3,433,220,303.10** | 7,853,265,610.47 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | |
|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 3,066,219,337.01 | 2,843,706,988.73 | 222,512,348.28 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 3,066,219,337.01 | 2,843,706,988.73 | 222,512,348.28 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,851,224,437.01 | 2,618,449,488.73 | 232,774,948.28 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,916,578,867.00 | 1,735,745,742.19 | 180,833,124.81 |
| 210101 | Үндсэн цалин | 1,414,450,939.00 | 1,259,690,293.19 | 154,760,645.81 |
| 210102 | Нэмэгдэл | 473,900,828.00 | 443,133,163.00 | 30,767,665.00 |
| 210104 | Урамшуулал | 28,227,100.00 | 32,922,286.00 | (4,695,186.00) |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 244,722,638.00 | 221,599,481.13 | 23,123,156.87 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 166,476,133.72 | 153,682,931.17 | 12,793,202.55 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 19,581,185.46 | 17,847,059.16 | 1,734,126.30 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 15,658,328.35 | 13,958,427.45 | 1,699,900.90 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,909,717.33 | 3,308,670.36 | 601,046.97 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 39,097,273.14 | 32,802,392.99 | 6,294,880.15 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 366,824,306.01 | 366,824,306.01 | - |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,795,602.01 | 11,795,602.01 | - |
| 210302 | Түлш, халаалт | 310,387,000.00 | 310,387,000.00 | - |
| 210303 | Цэвэр, бохир ус | 44,641,704.00 | 44,641,704.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 78,864,300.00 | 54,788,140.00 | 24,076,160.00 |
| 210502 | Хоол, хүнс | 78,864,300.00 | 54,788,140.00 | 24,076,160.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,499,526.00 | 7,490,895.00 | 2,008,631.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,499,526.00 | 7,490,895.00 | 2,008,631.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 35,087,700.00 | 35,032,510.00 | 55,190.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,303,500.00 | 12,303,500.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 22,784,200.00 | 22,729,010.00 | 55,190.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 199,647,100.00 | 196,968,414.40 | 2,678,685.60 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 165,470,700.00 | 162,792,014.40 | 2,678,685.60 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 34,176,400.00 | 34,176,400.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 214,994,900.00 | 225,257,500.00 | (10,262,600.00) |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 214,994,900.00 | 225,257,500.00 | (10,262,600.00) |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 214,994,900.00 | 211,057,500.00 | 3,937,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 14,200,000.00 | (14,200,000.00) |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 3,066,219,337.01 | 3,105,718,754.11 | (39,499,417.10) |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,620,306,000.00 | 2,598,716,000.00 | 21,590,000.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,620,306,000.00 | 2,598,716,000.00 | 21,590,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 14,370,269.10 | (14,370,269.10) |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 445,913,337.01 | 445,913,337.01 | - |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 445,913,337.01 | 445,913,337.01 | - |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | | 46,719,148.00 | (46,719,148.00) |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 12,303,500.00 | (12,303,500.00) |
| 1200047 | шилжиж ирсэн хөрөнгө | | 34,415,648.00 | (34,415,648.00) |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **262,011,765.38** | (262,011,765.38) |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 109.00 | 109.00 | - |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 80.00 | 80.00 | - |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 28.00 | 28.00 | - |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 1,898.00 | 1,898.00 | - |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 1,898.00 | 1,898.00 | - |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 1,898.00 | 1,898.00 | - |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **8,894,469.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **5,401,185.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 1,480,585.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 834,085.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 834,085.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 646,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 646,500.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **3,920,600.00** |
| 213305 | Нэмэлтийн дансны үлдэгдэл төвлөрүүлэх шилжүүлэг | | 3,920,600.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **3,493,284.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 3,493,284.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 3,493,284.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 8,894,469.10 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 8,894,469.10 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 8,894,469.10 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 107.4 сая төгрөгийн 7 алдаа[1] илэрснээс аудитын явцад 107.4 сая төгрөгийн 7 алдааг залрууллаа.

### Залруулсан алдаа:

1. Үндсэн хөрөнгийн ашиглах жилийг 14 хөрөнгөд тавиагүйгээс 5.0 сая төгрөгийн элэгдэл тооцогдоогүйг залруулсан.
2. Хасагдсан хөрөнгийн 1.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг бүрэн хасаагүй, элэгдлийн зардлыг 1.0 төгрөгөөр илүү тооцсоныг залруулсан.
3. Шилжиж ирсэн 3 хөрөнгийн 4.7 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг бүртгээгүй байсныг залруулсан.
4. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналын эцсийн үлдэгдэл санхүү тайлангийн үндсэн хөрөнгийн үлдэгдлээс 76.7 сая төгрөгөөр зөрүүтэй байсныг залруулсан.
5. Сурах бичиг түрээслүүлсний 12.3 сая төгрөгийн орлого болон бусад түрээсийн орлогын 50 хувь болох 4.1 сая төгрөгийг үр дүнгийн тайланд орлогоор бүртгэснийг залруулсан.
6. Байгууллагаас авах 1.5 сая төгрөгийн авлагыг хөрөнгийн дансаар дамжуулалгүй шууд зардалд бүртгэснийг залруулсан.
7. ХХОАТ-ын 0.9 сая төгрөгийн өр төлбөр бүртгээгүй байсныг залруулсан.

Аудитаар нийт 2 зөрчил[2] илэрснээс 0.3 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага хүргүүлсэн.

### 3.1 Төлбөрийн акт

Тайлант хугацаанд 2022 оны ажлын үр дүнг үнэлж, сумын Засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын удирдах албан тушаалтанд 12 дугаар сард үндсэн цалингийн 27 хувиар буюу 0.3 сая төгрөгийг тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.18, 14.1.19-д зааснаас бусад төсвийн”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “Батлагдсан

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

### 3.2 Албан шаардлага

1. **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 4,042.4 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 2,847.4 сая төгрөгийн 57 гүйлгээ, 226.1 сая төгрөгийн 26 шийдвэрийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 359.0 сая төгрөгийн орлогын 12 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 276.6 сая төгрөгийн зарлагын 17 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 81.4 сая төгрөгийн 4 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"; заалтуудтай нийцээгүй байна.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгийн ашиглах жил 14 хөрөнгөд тавигдаагүйгээс 5.0 сая төгрөгийн элэгдэл тооцогдоогүйг залруулсан. илүү тооцсоныг залруулсан. | 1 | 5,013.9 | | | 1 | 5,013.9 | 1 | 5,013.9 | | | | |
| Хасагдсан хөрөнгийн 1.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг бүрэн хасаагүй, элэгдлийн зардлыг 1.0 төгрөгөөр илүү тооцсоныг залруулсан. | 1 | 2,215.1 | | | 1 | 2,215.1 | 1 | 2,215.1 | | | | |
| Шилжиж ирсэн 3 хөрөнгийн 4.7 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг бүртгээгүй байсныг залруулсан. | 1 | 4,745.0 | | | 1 | 4,745.0 | 1 | 4,745.0 | | | | |
| Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналын эцсийн үлдэгдэл санхүү тайлангийн үндсэн хөрөнгийн үлдэгдлээс 76.7 сая төгрөгөөр зөрүүтэй байсныг залруулсан. | 1 | 76,700.9 | | | 1 | 76,700.9 | 1 | 76,700.9 | | | | |
| Түрээсийн номын 12.3 сая төгрөгийн орлого болон бусад түрээсийн 50 хувь болох 4.1 сая төгрөгийг үр дүнгийн тайланд орлогоор бүртгэснийг залруулсан. | 1 | 16,387.8 | | | 1 | 16,387.8 | 1 | 16,387.8 | | | | |
| Байгууллагаас авах 1.5 сая төгрөгийн авлагыг шууд зардалд бүртгэснийг залруулсан | 1 | 1,502.5 | | | 1 | 1,502.5 | 1 | 1,502.5 | | | | |
| ХХОАТ-ын 0.9 сая төгрөгийн өр төлбөр бүртгээгүй байсныг залруулсан. | 1 | 901.1 | | | 1 | 901.1 | 1 | 901.1 | | | | |
| **Дүн** | **7** | **107,466.3** | **-** | **-** | **7** | **107,466.3** | **7** | **107,466.3** | **-** | **-** | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тайлант хугацаанд 2022 оны ажлын үр дүнг үнэлж, сумын Засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын удирдах албан тушаалтанд 12 дугаар сард үндсэн цалингийн 27 хувиар буюу 0.3 сая төгрөгийг тооцож олгосон байна. | 1 | 319.3 | 1 | 319.3 | | | | | | | | |
| Дүн | 1 | 319.3 | 1 | 319.3 | | | | | | | | - |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 4,042.4 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 2,847.4 сая төгрөгийн 57 гүйлгээ, 226.1 сая төгрөгийн 26 шийдвэрийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 359.0 сая төгрөгийн орлогын 12 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 276.6 сая төгрөгийн зарлагын 17 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 81.4 сая төгрөгийн 4 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. | 1 | | - | - | 1 | - | | |
| **Дүн** | **1** | | **-** | **-** | **1** | **-** | | |